

Хамт Олонд Суурилсан Хөгжлийн Хөтөлбөрийн 2009 тайлан

Хамт Олонд Суурилсан Хөгжлийн Хөтөлбөр (ХОСХХ) нь 2009 онд ХУД-ийн 5-р хороо, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Дархан- Уул аймгийн Дархан хот зэрэг газруудад нутгийн хамтлагуудийн санаачлага, оролцоотойгоор орон нутгийн засаг захиргаатай түншлэлийг бий болгож, зохистой орон байрны эрх, зохистой амьдрах орчин гэх мэт тохижилтын хүрээнд тодорхой үйл ажилгаануудыг хийсэн. Мөн нутгийн хамтлагууд чадавхижуулах сургалтад хамрагдан тухайн орон нутагт цаашилбал бүлгүүдийн ажлын байран дээр очиж туршлага солилцож, бие биенээсээ суралцаж мэдлэгээ солилцсон юм.

Үйл ажиллагаа: хамрагсад, өөрчлөлт ба түүний үр дүн

ХОСХХ нь 2009 онд Орон Байрны Эрхийг Хангах Азийн Эвсэлээс АККА хөтөлбөрийг 3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж эхэлсэн. Мөн Шинэ Зеландийн Бээжин дэх Элчин Сайдын Яамны санхүүжилттэй МХБ-үүдийн Туршлага Солилцох уулзалт, Тогтвортой Амьжиргаа-2 төслийн хүрээнд 10-р гудамжны тохижилт болон 11-р гудамжны иргэдийн өөрсдийн санаачлагаар тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг ажлуудын хүрээнд тухайн орон нутгийн захиргаа, МХБ-үүд болон ХЭХТ хамтарч ажиллаасан.

- ▶ АККА Хөтөлбөрийг 2009 – 2011 хэрэгжилт:
 - Шинэ Мөнгөн Хуримтлалын Бүлгүүд МХБ-үүд
 - Тохижилтын ажлууд
 - Сургалтууд: Хамт олныг зохион байгуулалтанд оруулах, интэрнэт, бүлгийн дотоод ардчилалыг бий болгох г.м
 - МХБЗ, Эргэлтийн сан
 - Хотын судалгаа
- ▶ Тохижилтын ажлууд
- ▶ Туршлага Солилцох уулзалт, Баримтат Кино
- ▶ ХЭХТ Зээл

Шинэ МХБ

АККА хөтөлбөрийн хүрээнд 5-р хорооны МХБ-үүдийн дунд болзолт уралдаан зарлаж ХУД-ийн 5-р хороонд 5 шинэ МХБ-үүдийг “Сор”, “Мандахнар”, “Ивээл” МХБ-үүд байгуулсан байна. Уг уралдаанд “Сор” МХБ түрүүлж орон нутгийн иргэдээ манлайлан үлгэр жишээ үзүүлж 5-р хороонд “Од” МХБ, “Ахиц” МХБ-г 21-р гудамжинд байгуулан тогтворжуулах бүхий л арга зүй, зөвлөгөөгөөр хангаж байна. Иргэдийг гудамж гудамжаар нь зохион байгуулалтанд оруулж “Од”, “Ахиц”, “Уран Хас”, “Их Эхлэл”, “Дэлгэрэх”, “Чандмань” шинэ МХБ-үүдийг байгуулан ажиллаж байна.

Дархан хотод “Баянсанаа”, “Оргил”, “Есөн-Эрдэнэ”, “Амонда”, “Бараат”, “Тэмүүлэл”, “Дэм Дэмэндээ” нийт 7 шинэ МХБ байгуулсанаас үүний 3 МХБ нь хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн ажилчидаас бүрдсэн ба 1 МХБ нь алслагдсан 4-р багийн Уужимбулагт, 2 бүлэг нь орон сууцны хороололд, 1 бүлэг нь гэр хорооллын тэтгвэрийн хөгшчүүлийг хамарсан юм. “Баянсанаа” ба “Оргил” МХБ-үүд орон байр болон амьдрах орчны тохижилтод анхаарч өөрсдийн хуримтлал болон АККА хөтөлбөрийн хүрээнд тохижилтын шаталсан ажлуудыг хийж эхэлсэн.

“Амонда” бүлэг нь өөрсдийн хуримтлалаар хүлэмжийг байгуулж өргөст хэмх, улаан лооль зэрэг хүнсний ногоог тарьж ургуулан улмаар ургац хураалтын үед даршлаж өөрсдийн болон нутгийн иргэдийг хүнсний ногоогоор хангажээ.

Уужимбулаг буюу 4-р багт орших “Дэм Дэмэндээ” МХБ нь газар тариалан эрхэлдэг бөгөөд тэдний нийтлэг тулгамдсан асуудал нь газар эзэмшил байна. Хил залгаа орших орон нутгаас олон малтай иргэд Уужимбулагт нүүн нутагшиж тухайн орон нутгийн иргэдийн бэлчээрийн болон тариалангийн газрыг ашиглах боломжгүй болгож байна.



Баянсанаа, Оргил, Есөн-Эрдэнэ
МХБ



Дэм Дэмэндээ МХБ – 4-р баг

Тохижилтын ажлууд

АККА хөтөлбөрийн хүрээнд Дархан хотын “Баянсанаа”, “Оргил” МХБ-үүдийн гишүүд өөрсдийн санаачлагатайгаар амьдардаг нийтийн байрны дотоод засал болон гаднах орчны тохижилтыг хийж эхэлсэн байна. ХУД-ийн 5-р хорооны “Чандмань” МХБ нь 5-р хорооны 13-15р гудамжны тохижилтын ажлыг 2010 оны 4 сараас эхлэнэ.



“Баянсанаа” “Оргил” МХБ:
цахилгааны монтаж сольсон нь



“Баянсанаа”, “Оргил” МХБ: гадаад
орчины тохижилт эхний ээлж

МХБЗөвлөл ба Хамт Олныг Хөгжүүлэх Сан

ХУД-ийн 5-р хороо, Өвөрхангай, Дархан хотын МХБ-үүдийн дунд МХБЗөвлөл ба ХОХСанг иргэд, орон нутгийн захиргаа ба ХЭХТ гэсэн гурвалсан байдлаар байгуулсан. МХБЗөвлөл нь тухайн орон нутгийн МХБ-үүдийн гишүүдээс бүрдэх ба бүлэг бүрээс нэг гишүүнийг бүлэг дотроо сонгосон. ХОХСан нь Удирдах Зөвлөл, хяналтын зөвлөл, нягтлан, няраваас бүрдэх ба бүх бүлгүүдийн дунд нээлттэй сонгуулиар сонгосон юм. Орон нутгийн захиргаанаас ХУД-ийн ЗДТГ-ын дарга Ц. Отгонбагана, Дархан хотын захирагчийн албаны дарга Х. Бааст, Өвөрхангай аймагт ЗДТГ-ын орлогч дарга Ж.Батжаргал нар сонгогдсон байна. МХБЗөвлөлийн үйл ажиллагаа нь 5-р хороо, Өвөрхангай, Дархан хотуудад тогтворжиж байнга уулзалдалж тухайн цагийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж санал бодлоо солилцож үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргадаг.

Өвөрхангай аймгийн ХОХСанд Өвөрхангай аймгийн ЗДТГ-аас 1 сая төгрөгийг байршуулж бүлгийн гишүүдэд зээл олгож эхэлсэн. ХУД-ийн ТГ-аас иргэдийг бусад зээлд хамруулах гэх мэт арга хэмжээг авахаа

мэдэгдсэн байна. 5-р хорооны том төслийн хүрээнд ХОХТөвийн байр барих саналтай байгаа ба ХУД-ын ТТ-аас газрыг үнэгүй өгөх батламж гаргасан.



Өвөрхангай: МХБЗөвлөл байгуулагдаж байгаа нь



5-р хороо: МХБЗөвлөлийн уулзалт



5-р хороо: ХОХСангийн уулзалт

Сургалтууд

ХОСХХ нь МХБ-үүдэд МХБ-ийг хэрхэн байгуулах тухай сургалтыг 6 удаа 5-р хороо, Дархан хот, Өвөрхангайд зохион байгуулж, 150 хүн хамрагдаж 13 шинэ МХБ байгуулсан байна. Мөн АККА хөтөлбөрийн хүрээнд АККА хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүй сургалт, интернэтийн сургалт, хамт олныг хэрхэн зохион байгуулалтанд оруулах, МХБ-ийн дотоод ардчилал зэрэг сургалтуудыг ХУД-ийн 5-р хороо, Өвөрхангай болон Дархан хотуудад зохион байгуулжээ. Сургалтуудыг агуулгад нийцсэн тоглоом, хэлэлцүүлэг хэлбэрээр явуулсан болно.



Хөлбөмбөг: Хамт Олныг Хэрхэн Зохион байгуулалтад оруулах нь сургалт

Иргэд байгууллагын хүсэлтээр Багануур дүүрэг, Чингэлтэй дүүрэгт МХБ байгуулах сургалтыг зохион байгуулсан байна. Үүний үр дүнд иргэд ХЭХТ болон хамт олон болон ажиллахын ашиг тусыг мэдэж бүлэгийн зохион байгуулалтад оржээ.

Судалгаа

Өвөрхангай, Улаанбаатар, Дархан хотын судалгааг бүлгийн гишүүд өөрсдөө хийсэн. Үүнд нийт 65 гишүүд оролцсон.



Өвөрхангай аймгийн МХБ-ийн гишүүд судалгаа хийж байгаа нь

Хаана	Хамрагдсан байдал	Тулгамдсан асуудлууд
ХУД 5-р хороо	877 өрх	1. Хог – хорооны хогны машин байнгын бус, оршин суугчид гудамж руу хаядаг 2. Гудамжны гэрэлтүүлэг 3. Газар / жорлон – шинээр жорлон, муу усны нүх барих газаргүй
Өвөрхангай	2..... өрх	1. Гудамжны гэрэлтүүлэг 2. Явган зам 3. Нийтийн халуун ус 4. Сургууль завсардалт, цэцэрлэг 5. Худаг 6. Хог
Дархан	... өрх	1. Газрын эрсдэл – дотоодын шилжин суурьшгчид зөвшөөргүй газар буудаг 2. Жорлон 3. Худаг – 15-р багт худагын хомсдолтой

Туршлага солилцох уулзалтууд

Шинэ Зеландийн Бээжин дэх Элчин Сайдын Яамны санхүүжилттэйгээр ХУД-ийн 5-р хороо болон Өвөрхангай аймгийн МХБ-үүдийн хооронд туршлага солилцох уулзалтыг 6, 7 сард нийт 50 оролцогчдын хүрээнд зохион байгууллаа. Уг туршлага солилцох уулзалтын зорилго нь орон нутгийн иргэд бие биенээсээ суралцах, мэдлэгээ солилцох, бэрхшээлийг хэрхэн хамтдаа даван туулах, хэтийн төлөвлөгөө гэх зэргийг хэлэлцсэнээс гадна хэрхэн сайн манлайлагч байх, хэрхэн хамт олныг зохион байгуулалтанд оруулах, хэрхэн МХБ байгуулах, хэрхэн нутгийн захиргаатай хамтран ажиллах гэх мэт сургалтад хамрагдаж бие биентэйгээ мэдлэг, мэдээллээ солилцлоо.

Уг уулзалтуудын явцад МХБ-ийн гишүүд бие биентэйгээ улам танилцаж, газар дээрх туршлагаас хуваалцсан. Орон нутгийн захиргаатай хэрхэн хамтран ажиллаж болох талаар бие биентэйгээ санал бодолоо солилцлоо. Уулзалтын үер оролцогчдын зүгээс дахин туршлага солилцох уулзалтууд болон хүний эрх болон хуулийн тухай чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулахыг хүслээ.



ХУД 5-р хороо: Туршлага солилцох уулзалт- сургалтын үеэр



МХБ-үүдийн үйл ажиллагаатай танилцаж суралцаж байгаа нь

Баримтат кино

Шинэ Зедандын Бээжин дэх Элчин Сайдын Яамны дэмжлэгтэйгээр МХБ-үүдийн тухай баримтат киног “G Entertainment”-тай хамтран бүтээлээ. Уг кинобүтээл нь орон даяар UBS сувгаар 8-р сард давталттайгаар цацагдсан байна. Киноны зорилго нь МХБ-үүдийн үйл ажиллагааг орон даяар сурталчлах, туршлага солилцох үйл ажиллагааг баримтжуулах явдал байлаа. Энэхүү киног алслагдсан аймгууд болон сумдын иргэд үзэж санал сэтгэгдэлээ 5-р хорооны болон Өвөрхангай амийгийн МХБ-үүдийн гишүүдтэй хуваалцсан байна. Кинобүтээлийг хувилан Дорнод аймаг дах ХЭХТ-ийн МХБ-үүд, Дархан хот дах ХЭХТ-ийн МХБ-үүд мөн Завхан аймгийн Эмэгтэйчүүдийн ТББ-т тараасан.

Тохижилтын ажил

Тогтвортой амьжиргаа - 2 төслийн хүрээнд 10,11-р гудамжны бүх иргэдийн оролцоотойгоор орчны тохижилтын ажлыг “Их Эхлэл” “Мандах” МХБ-үүдийг байгуулан амжилттай хийсэн. Мөн, Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд “Тодгялбаа” МХБ нь өөрийн орших 8-р багт тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн “Шилдэг гудамж” өргөмжлөлийг АЗДТГ-аас хүртсэн байна.

Шинээр байгуулагдсан “Уран Хас”, “Од” МХБ-үүд нь 5-р хороонд үлгэр жишээ бүлэг болохоо тохижилтын ажлыг өөрсдийн хуримтлалаар хийж болдогыг харуулсан юм. Жишээ нь, “Од” МХБ нь бүлгийн хурлаар тулгамдсан асуудлаа тодорхойлсон нь нурж унах дөхсөн хашаа ба хаалга байсан юм. Энэхүү үйл ажиллагаанд бүлгийн бүх гишүүдийн нэрсийг бичэн сугалаа сугалж ээлж дараалан хийх гишүүдийн нэрсийг гарган эхний 2 айлын хаалгыг хуримтлалын хөрөнгөөрөө хийсэн байна.



10-р гудамж

“Тод Гялбаа” МХБ:
Өвөрхангай

“Уран Хас” МХБ: 5-р хороо



“Од” МХБ: 5-р хороо

ХЭХТ зээл

Зээлийн төрөл	Хэмжээ ₮	Нэгж	Нийт
Орон байрны нөхцөл сайжруулах	500000	8	4000000
Улиралын чанартай	300000	2	600000
Бүлэг чадавхижуулах	500000	4 МХБ	2000000
Бүлэг чадавхижуулах	905000	1 МХБ	905000
Нийт			7505000

Эерэг өөрчлөлтүүд

2005 оноос өнөөг хүртэл 5 жилийн үр дүнд иргэд тохижилтын ажилд санаачлагатай оролцож байна. Мөн, иргэд орон нутгийн засаг захиргаатай хамтарсан гэрээ байгуулах, хамтран ажиллахыг шамдаж өөрсдийн идэвхи зүтгэлтэйгээр хамтын ажиллагааны гэрээг байгуулсан байна. Жишээ нь, ХУД-ын 5-р хорооны 18-р гудамжинд “Уран Хас” МХБ 6 айлын хашааг хамтын хуримтлалын хөрөнгөөр янзалсан, 21-р гудамжинд “Од” МХБ 2 айлын хаалга шинэчилсэн, 10-11-р гудамжууд гудамжны тохижилтын ажлууд, Дархан хотын “Баянсанаа”, “Оргил” МХБ-үүд орон байрны тохижилтыг, Өвөрхангай амгийн “ТодГялбаа” МХБ гудамжны тохижилт зэргийг өөрсдийн санаачилгаар хийсэн.

МХБ-үүд дотроо ахлагч, нягтлан, няраваа ардчилсан сонгуулийн журмаар 6 сар тутам сонгодог болсон нь дотоод ардчилалын процессийг орон нутагт бий болгож байгаагийн жишээ юм.

Шинэ механизм, шинэ бүтэц, хандлага зохион байгуулалттай болж үйл явцад иргэд оролцдог болсон нь МХБ-үүдийн тогтвортой байдлыг хангаж байна. МХБЗөвлөл, Хамт Олныг Хөгжүүлэх Санг ХУД-ын 5-р хороо, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Дархан хотуудын МХБ-үүд байгуулсан. Орон нутгийн засаг захиргаа, ХЭХТ ба МХБ-үүдийн төлөөлөл гэх мэт 3 талын төлөөлөлтэй юм. Орон нутгийн захиргаа нь тухайн орон нутгийн иргэдтэй хамтын ажиллагаатай, нягт холбоо харилцаатай болсон.

- ▶ МХБ-үүд өөрсдийн санаачлагаар тохижилтын ажлыг хийдэг болсон
- ▶ МХБ-үүд МХБЗөвлөл болон Хамт Олныг Хөгжүүлэх Сангийн дүрмийг өөрсдөө боловсруулсан
- ▶ МХБЗөвлөл болон Хамт Олныг Хөгжүүлэх Санд орон нутгийн захиргаанаас төлөөлөл оруулсан
- ▶ МХБЗөвлөл нь тухайн орон нутгийн захиргаатай хамтын ажиллагааны гэрээ

Хөтөлбөрийн ажилласан хүрээ

№	Үйл ажиллагаа		Хаана	Тоо
1	Сургалт	МХБ байгуулах нь	ХУД 5-р хороо, Өвөрхангай, Дархан Багануур ЧД	137
		АККА Хөтөлбөр	ХУД, Өвөрхангай, Дархан,	150
		Англи хэл	ХУД	50
2	Хурал, чуулган		ХБМСТ-ХЭХТ хамтарсан	40
3	Уулзалт, хэлэлцүүлэг		ХУД, Дархан, Өвөрхангай	690
4	Тохижилтын ажилууд		ХУД, Өвөрхангай, Дархан	119
Нийт				1186